

**ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН УРЬДЧИЛАН ТАНДАН
СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН**

2024 он

АГУУЛГА

1. Асуудлын дүн шинжилгээ, шийдвэрлэх зорилго
2. Зохицуулалтын хувилбарууд, тэдгээрийн харьцуулалт
3. Зохицуулалтын хувилбарын үр нөлөө
4. Харьцуулсан дүгнэлт
5. Зөвлөмж

Нэг. Асуудлын дүн шинжилгээ, асуудлыг шийдвэрлэх зорилго

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг нь Төрийн сүлд, туг, далбаа, тамга, дуулал мөн.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ.”, Гучдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.” гэж заасан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт эрхэмлэн хамгаалах үндэсний эв нэгдэл зорилгын хүрээнд ... ард түмнийхээ эв нэгдлийг бэхжүүлэх зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулиар Монгол Улсын Төрийн сүлд, туг, далбаа, тамгыг үйлдэх, дүрслэх, дээдлэн хэрэглэх журмыг хуульчлан зохицуулж байгаа бөгөөд уг хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт төрийн далбааг байнга мандуулах байршлыг хуульчилсан бөгөөд уг хуулийн 25 дугаар зүйлд иргэд, өрх, аж ахуйн нэгж, байгууллага нь төрийн бэлгэ тэмдгээ гүнээ дээдлэн хүндэтгэж, бүх ард түмний баяр наадам, ёслол, хүндэтгэлийн арга хэмжээ болон бусад үед Төрийн сүлд, далбаагаа барих байрлуулах, мандуулах буюу Төрийн дууллыг эгшиглүүлж болохоор заасан.

Төрийн далбаандаа хүндэтгэлтэй хандах, түүхт ёс, түүхэн уламжлалаа нандигнан өвлөх, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, улс орноо сурталчлах, эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор төрийн далбааг байнга мандуулах эрх зүйн орчинг сайжруулах, түүнчлэн төрийн далбааг иргэн, хуулийн этгээдэд дурсгал болгон хадгалуулах зохицуулалтын хамрах хүрээг өргөжүүлэх шаардлагатай байна.

Дээр дурдсан үндэслэл, шаардлагын дагуу Төрийн бэлгэ тухай хуульд нэмэлт оруулах шаардлагатай байна.

2. Зохицуулалтын хувилбарууд, тэдгээрийн харьцуулалт

Энэхүү судалгааны 1 дэх хэсэгт тодорхойлсон асуудал, түүнийг үүсгэж буй шалтгаан нөхцлийг арилгах арга замын хувилбарыг зорилгод хүрэх байдал, зардал үр өгөөж, үр нөлөөний байдлаар дараах байдлаар харьцуулан үзэв.

2.1 Асуудлыг зохицуулах хувилбар

2.1.1. "Тэг" хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах:

2.1.2. Хэвлэл мэдээлэл болон бусад хэрэгслийг ашиглан олон нийтэд хандсан ухуулга сурталчилгааны ажил өрнүүлэх:

2.1.3. Зах зээлийн эдийн засгийн хэрэгслийг ашиглан төрөөс зохицуулалт хийх:

2.1.4. Төрөөс санхүүгийн интервенц хийх:

2.1.5. Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх:

2.1.6. Захиргааны шийдвэр гаргах:

2.1.7. Хуулийн төсөл боловсруулах:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван хоёрдугаар зүйлийн 7 дахь хэсэгт “Төрийн бэлгэ тэмдгийг дээдлэн хэрэглэх журам, төрийн дууллын үг, аяыг хуулиар бататгана.” гэж заасан бөгөөд Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Монгол Улсын Төрийн сүлд, туг, далбаа, тамгыг үйлдэх, дүрслэх, дээдлэн хэрэглэх журмыг зохицуулна гэж заасан.

Асуудлыг шийдвэрлэх хувилбаруудыг харьцуулж тоймлон үзвэл:

Хувилбар	Зорилгод байдал	хүрэх	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
Тэг хувилбар	зорилгод боломжгүй	хүрэх	Зардал гарахгүй боловч асуудлаас үүдэн бий болж байгаа сөрөг үр дагавар үргэлжилнэ.	Үр дүнгүй
Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Боломжгүй		Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй зорилгод боломжгүй.	тул хүрэх	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
Төрөөс санхүүгийн интервенци хийх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй зорилгод боломжгүй.	тул хүрэх	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй зорилгод боломжгүй.	тул хүрэх	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй

Захиргааны шийдвэр гаргах	Асуудал нь хуулийн зохицуулалтаас үүдэлтэй бөгөөд захиргааны шийдвэр гаргах замаар шийдвэрлэгдэхгүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Үүсээд байгаа шалтгаан нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн зохицуулалтаас үүдэлтэй бөгөөд хуулийн хүчин чадлаас дээгүүр захиргааны шийдвэр гарахгүй тул зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Монгол Улсын Үндсэн хуулийн Арван хоёрдугаар зүйлийн 7 дахь хэсэгт “Төрийн бэлгэ тэмдгийг дээдлэн хэрэглэх журам, төрийн дууллын үг, аяыг хуулиар бататгана.” гэж заасан бөгөөд Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Монгол Улсын Төрийн сүлд, туг, далбаа, тамгыг үйлдэх, дүрслэх, дээдлэн хэрэглэх журмыг зохицуулна гэж заасан.	Зардал гарна.	Үр дүнтэй.

Хувилбаруудын зорилгод хүрэх байдал болон эерэг ба сөрөг талыг зардал, үр өгөөжөөр харьцуулсны үр дүнд "хуулийн төсөл боловсруулах" нь асуудлыг шийдвэрлэх ганц хувилбар байгаа буюу хууль гаргах хэрэгцээ, шаардлагатай гэж үзэн тул тандан судлах ажиллагааг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5.2-т заасны дагуу хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл хэлбэрээр боловсруулна.

Гурав.Зохицуулалтын хувилбарын үр нөлөө

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 1. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө; 2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг энэ хэсгээр нарийвчлан судаллаа.

3.1. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө:

3.1.1 Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө: Хуулийн төсөл нь хүний эрхэд аливаа сөрөг нөлөө (хязгаарлах, хориглох) үзүүлэхгүй.

3.1.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө: Сөрөг нөлөө үзүүлэхгүй.

3.1.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө: Сөрөг нөлөө үзүүлэхгүй.

3.1.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө: Хууль батлагдсанаар бүгд байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

3.2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцтэй байдал:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг нь Төрийн сүлд, туг, далбаа, тамга, дуулал мөн.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ.”, Гучдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.” гэж заасан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт эрхэмлэн хамгаалах үндэсний эв нэгдэл зорилгын хүрээнд ... ард түмнийхээ эв нэгдлийг бэхжүүлэх зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулиар Монгол Улсын Төрийн сүлд, туг, далбаа, тамгыг үйлдэх, дүрслэх, дээдлэн хэрэглэх журмыг хуульчлан зохицуулж байгаа бөгөөд уг хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт төрийн далбааг байнга мандуулах газрыг хуульчилсан бөгөөд уг хуулийн 25 дугаар зүйлд иргэд, өрх, аж ахуйн нэгж, байгууллага нь төрийн бэлгэ тэмдгээ гүнээ дээдлэн хүндэтгэж, бүх ард түмний баяр наадам, ёслол, хүндэтгэлийн арга хэмжээ болон бусад үед Төрийн сүлд, далбаагаа барих байрлуулах, мандуулах буюу Төрийн дууллыг эгшиглүүлж болохоор заасан.

Төрийн далбаандаа хүндэтгэлтэй хандах, түүхт ёс, түүхэн уламжлалаа нандигнан өвлөх, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, улс орноо сурталчлах, эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор төрийн далбааг байнга мандуулах эрх зүйн орчинг сайжруулах, түүнчлэн төрийн далбааг иргэн, хуулийн этгээдэд дурсгал болгон хадгалуулах зохицуулалтын хамрах хүрээг өргөжүүлэх шаардлагын хүрээнд Үндсэн хууль, Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нийцүүлэн боловрсуулсан.

Дөрөв. Хувилбарын харьцуулсан дүгнэлт

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хувилбарыг аргачлалд дурдсан шалгуур үзүүлэлтийн дагуу дараах байдлаар дүгнэв:

Шалгуур үзүүлэлт	Зохицуулалтын хувилбар: Хууль гаргах
-------------------------	---

	<p>Монгол Улсын Үндсэн хуулийн Арван хоёрдугаар зүйлийн 7 дахь хэсэгт “Төрийн бэлгэ тэмдгийг дээдлэн хэрэглэх журам, төрийн дууллын үг, аяыг хуулиар бататгана.” гэж заасан бөгөөд Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Монгол Улсын Төрийн сүлд, туг, далбаа, тамгыг үйлдэх, дүрслэх, дээдлэн хэрэглэх журмыг зохицуулна гэж заасан.</p>
Зорилгод хүрэх байдал	<p>Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулиар Монгол Улсын Төрийн сүлд, туг, далбаа, тамгыг үйлдэх, дүрслэх, дээдлэн хэрэглэх журмыг хуульчлан зохицуулж байгаа бөгөөд уг хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт төрийн далбааг байнга мандуулах байршлыг хуульчилсан бөгөөд уг хуулийн 25 дугаар зүйлд иргэд, өрх, аж ахуйн нэгж, байгууллага нь төрийн бэлгэ тэмдгээ гүнээ дээдлэн хүндэтгэж, бүх ард түмний баяр наадам, ёслол, хүндэтгэлийн арга хэмжээ болон бусад үед Төрийн сүлд, далбаагаа барих байрлуулах, мандуулах буюу Төрийн дууллыг эгшиглүүлж болохоор заасан. Төрийн далбааг байнга мандуулах байршлыг Монгол Улсын Ерөнхийлөгч тогтоож болохоор, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд улс орноо сурталчлах, эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор төрийн далбааг иргэн, хуулийн этгээдэд хүндэтгэлтэйгээр гардуулан өгөх эрх зүйн зохицуулалтын хүрээг өргөжүүлэх.</p>
Хүний эрх, эдийн засаг байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	Эерэгээр нөлөөлнө.
Зардал үр өгөөжийн харьцаа	Хуулийг хэрэгжүүлснээр гарах үр өгөөж гарах бөгөөд зардлыг тусгайлан тооцно.
Гарч болох сөрөг үр дагаврыг илрүүлэх	Байхгүй.
Хууль тогтоомжтой нийцтэй эсэх	Нийцтэй.
Тухайн зохицуулалтаар хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдийг тогтоох	Сонгуульд нэр дэвшигч иргэн

Тав. Зөвлөмж

Энэхүү судалгааны ажлаар төрийн далбааг байнга мандуулах байршлыг Монгол Улсын Ерөнхийлөгч тогтоож болохоор, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд улс орноо сурталчлах, эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор төрийн далбааг иргэн, хуулийн этгээдэд

хүндэтгэлтэйгээр гардуулан өгөх эрх зүйн зохицуулалтыг сайжруулах хүрээнд Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах шаардлагатай болохыг дүгнэлээ.

---oOo---